

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
10 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-12
	1. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл	5-6
	2. Хоёр. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	6-12

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 09-ний
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж 52,6 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Амарзаяа, Д.Лүндээжанцан, Б.Жавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Н.Энхболд;

Тасалсан: О.Баасанхүү, Д.Сумъяабазар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат санал хэлэв.

Нэг. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, референт Б.Золбоо нар байлцав.

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай саналыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан намын зөвлөлийн дарга Д.Эрдэнэбат нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

С.Бямбацогт: Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн 9

Татгалзсан 1

Бүгд 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, референт Б.Золбоо нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Байнгын хорооны дарга С.Бямбацогт танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Д.Эрдэнэбат нар санал хэлэв.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 16.2-ыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	8
Татгалзсан	3
Бүгд	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Энэ хуулийн 16.1-д заасны дагуу биечлэн хүргэж танилцуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	4
Татгалзсан	7
Бүгд	11

35.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	8
Татгалзсан	3
Бүгд	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 30 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн ирж 63,1 хувийн ирцтэйгээр 16 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ Б.БАТГЭРЭЛ

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ 10 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Бямбацогт: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн Байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл

2. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Ийм хоёр асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу?

Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн гээд ярьчих шиг болох юм. Төрийн байгуулалтын байнгын хороонд Наранхүү гишүүнийг чөлөөлөөд Пүрэвдорж гишүүнийг оруулъя гэсэн хүсэлтээ бид гаргаад өгчихсөн шүү дээ. Яг хуулийнхаа дагуу байгаа. Эхлээд энийгээ хэлэлцчихээд, тэгээд Ёс зүйн дэд хороонд чинь Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс сонгогддог. Тэгэхээр одоо Пүрэвдорж гишүүнийгээ албажуулаад тэгээд Ёс зүйн дэд хороо руугаа орох юмаа яриад ингээд эрэмбэлээд явчихвал зөв байх аа гэж бодож байна. Тэр нь зөв байх.

С.Бямбацогт: Тэнд ямар нэгэн татгалзах зүйл байхгүй байгаа. Ганцхан чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.1.3-т “Улсын Их Хурлын дарга, нам, эвслийн бүлэг болон тэдгээрт харьяалагдаж буй гишүүдээс ирсэн саналыг нэгтгэн эцсийн хувилбарыг, нам, эвслийн бүлэг нь Байнгын хорооны тоо олонх, цөөнхийн харьцаа зэргийг харгалзан гишүүдийг Байнгын хороонд хуваарилах саналаа Улсын Их Хурлын даргад ирүүлнэ, энийг нэгдсэн хуралдаанд танилцуулна” гэсэн заалттай юм байна лээ.

Д.Эрдэнэбат: Би танилцуулъя гэсэн чинь та танилцуулахгүй гээд болиулчихсан шүү дээ. Би бичгээ өгчихсөн шүү дээ. Тэгсэн чинь Байнгын хороогоор орчихъё гэж.

С.Бямбацогт: Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох асуудлыг Байнгын хороо шийддэггүй, чуулганд шийддэг гээд.

Төрийн байгуулалтын байнгын хороонд орох асуудал нээлттэй, боломжтой. Энд ямар нэгэн эргэлзэх зүйл байхгүй гэж ингэж ойлгож болно. Ёс зүйн дэд хороонд орохдоо заавал Төрийн байгуулалтын байнгын хороонд орчихоод, дараа нь орох ёстой биш. Ёс зүйн дэд хороонд өөр Байнгын хорооны гишүүн орж болох бололцоотой. Энийгээ хэлэлцээд явчихъя. Маргаашийн чуулган дээр Төрийн

байгуулалтын байнгын хорооны асуудал нээлттэй. Нам, эвслийн бүлгийн саналаар шийдэгдэх учраас энд ямар нэгэн гацаа, түгжээ байхгүй байх гэж ойлгож байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.4-т Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаан Байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Дэд хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална. Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн Дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн тогтоол батлагдсанд тооцно.

Их Хурлын тухай хуулийн 24.6 “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын болон Ёс зүйн дэд хорооноос бусад Дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалагдах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд Дэд хорооны бүрэлдэхүүний тоо нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна гэсэн хуулийн дагуу энэ асуудал хэлэлцэгдэнэ.

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай саналыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Тогтохсүрэн хийнэ. Тогтохсүрэн даргад микрофон өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд МАН-ын бүлгээс одоо Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд байгаа Засгийн газрын гишүүний алба хашиж байгаа хоёр гишүүнийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээс чөлөөлж өгөөч гэсэн ийм хүсэлтээ тавьсан байгаа. Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Баделхан, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Сарангэрэл нарыг Дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж оронд нь Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр нарыг Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах ийм саналыг гаргаж байгаа юм. Энэ асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай саналыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн дарга Эрдэнэбат гишүүн танилцуулна.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Ёс зүйн дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Наранхүү байгаа. Тэгээд өөрийнх нь хүсэлтээр Ёс зүйн дэд хорооноос чөлөөлж Ардчилсан намын зөвлөлөөс Пүрэвдорж гишүүнийг нэр дэвшүүлж байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Тогтохсүрэн гишүүн, Эрдэнэбат гишүүн нарын гаргасан саналтай холбогдуулж асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж батлуулах

нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Та бүхэнд тогтоолыг уншиж танилцуулъя.

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан, Даваажанцангийн Сарангэрэл, Батсүхийн Наранхүү нарыг Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Дуламдоржийн Тогтохсүрэн, Бөхчулууны Пүрэвдорж нарыг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураал явуулъя.

Санал хураалтад 10 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 90 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Хаянхярваа гишүүн танилцуулъя. Энэ асуудлыг хэлэлцлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.9-д Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах бол холбогдох шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй гэсэн байгаа.

Хуулийн төслийг та бүхэнд тараасан байгаа. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээж авсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.8-д Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь

хүчингүй болгох, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэн баталж болно гэж.

Мөн 31.9-д Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах бол холбогдох шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй гэж тус тус заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг оруулж байна.

Төсөлд дараахь агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болно.

1.Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжийг журмын хуульд нэмж хууль хоорондын зөрчлийг арилгасан.

2.Мөн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх шатанд Байнгын хороо болон нам, эвслийн бүлэг саналын түвшинд харгалзан үзсэнээс бусад төсөлд тусгагдаагүй шинэ хэсэг заалтын саналын томъёолол санал, дүгнэлтэд оруулахгүй байхаар нэмэлт оруулсан.

3.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл гэсэн нэр томъёотой холбоотой нийт 26 хэсэг, заалтад холбогдох өөрчлөлтийг оруулж Үндсэн хуультай нийцүүлсэн.

4.Түүнчлэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлүүлэх бол нэмэлт, өөрчлөлтийн эхийг зөвшөөрнө, татгалзана гэснээс өөр асуудлаар ард нийтийн санал асуулгыг хамтатган явуулахыг хязгаарласан өөрчлөлтийг оруулсан.

5.Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг баталгаажуулахтай холбоотойгоор Ерөнхийлөгч ажлын 3 өдрийн дотор баталгаажуулахаар хугацаа заасан.

6.Төслийн гурав дахь хэлэлцүүлэгт санал хураалт явуулах үндэслэлийг тодорхой болгохтой холбоотой нэмэлтийг тус тус оруулсан байгаа.

Төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ төсөлтэй холбогдуулаад ер нь засаглалын тогтвортой байдал, институц хоорондын асуудлыг Үндсэн хуулиар нэлээн сайн зохицуулж өгсөн л дөө. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг нь байхгүй болгож байгаа юм байна. Энэ нь хуулийнхаа тайлбар дотор ингээд ерөөсөө бичээгүй, сэмхэн оруулчихсан. Тэгээд Их Хурлын гишүүд мэдэхгүй энийг шийдээд өнгөрөх юм байна л даа. Тэгэхээр та бид нарыг бодвол энэ чинь Монгол Улсын нийт иргэдээс сонгогдсон Ерөнхийлөгч хүн байгаа. Бид нар бол яахав дээ, жалгаас сонгогдсон ийм нөхдүүд байдаг.

Гэтэл та нар энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөө явуулахын тулд юу ч хамаагүй хийхээр шийдсэн юм байна л даа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр хориг тавих эрхийг нь байхгүй болгож байгаад, өөрөөр хэлбэл, ямар ч өөрчлөлт хийж болно, тэр өөрчлөлтийг нь хэн ч эсэргүүцэх боломжгүй болгож байгаад ингээд Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийгээд явах гэж байгаа юм байна. Энэ бол маш буруу.

Үндсэн хуулийг чинь өөрөө дөрөвний гурваар баталдаг юм шүү дээ. Тэгэхээр энэ гишүүд өөрөөр хэлбэл, дөрөвний гурваар баталж байна гэдэг бол маш өндөр хувиар баталж байна гэсэн үг. Гэтэл хоригийг гуравны нэгээр хүлээж авдаг. Нэгэнт л Их Хурлын гишүүд дөрөвний гурваар баталж байгаа юм бол тэр итгэл үнэмшилтэй байгаа тэр Их Хурлын гишүүн хоригийг хүлээж авахгүй гээд л кноп дарна шүү дээ. Ийм энгийн логик байж байхад чинь яагаад ингээд Ерөнхийлөгчийн хоригийг тавих эрхийг нь байхгүй болгож ингэж шийдэж байгаа юм бэ?

Ерөөсөө дураараа дургина, засаглалгүй, замбараагүй ажиллана гэсэн ийм илэрхийлэл энд явж байна шүү дээ. Энэ заалтыг хэн гэдэг хүн яаж оруулж ирсэн юм бэ, ямар шаардлагаар оруулж ирсэн юм бэ? Тэгээд яагаад ингээд Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд саяхан ард нийтийн санал асуулгын тогтоол дээр хориг тавьснаас болоод дараа, дараагийн зөндөө амьдрал үргэлжилнэ. Зөвхөн энэ Их Хурлаар асуудал дуусахгүй шүү дээ. Тэгээд бүх эрхийг нь ингээд байхгүй болгож байгаа, хориг тавих бүрэн эрхийг нь байхгүй болгож байгаа нь ямар учиртай юм бэ? Энэ дээр нэг хариулт өгөөч.

С.Бямбацогт: Сая Пүрэвдорж гишүүн өөрөө хэллээ. Үндсэн хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний гурав буюу 57 гишүүнээс дээш гишүүд дэмжиж байж батлагддаг ийм өндөр босготой. Нөгөө талаасаа ард нийтийн санал асуулгаар ард нийт дэмжих юм бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Үндсэн хууль батлагдах ийм хуультай. Үндсэн хууль болон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиараа.

Ийм болохоор өнөөдөр Үндсэн хуулийн хоригийн асуудал хэзээ ч яригдаж байгаагүй, цаашдаа ч. Сая хориг тавигдахдаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр тавигдаагүй, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж гарсан Улсын Их Хурлын 73 дугаар тогтоол дээр хориг тавигдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заасан бүрэн эрх дотор Монгол Улсын Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1. Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина гэж. Энэ Үндсэн хуульд хориг тавина гэсэн заалт байхгүй, Монгол Улсын Үндсэн хууль дотор. Тийм болохоор Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд ерөөсөө хориг тавиагүй. Журмын тухай хуулиар бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөл гэж явж байсан. Тэгвэл одоо бид нар Үндсэн хуульдаа нийцүүлээд Үндсэн хууль маань Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дээр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна гэж байгаа юм.

Яг энэний дагуу журмын хуулиа өөрчлөөд Үндсэн хуульдаа нийцүүлж байгаа. Яг үүнтэй адил Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь өөрөө Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр юм чинь Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд

заасан бүрэн эрхийн хүрээнд хууль, бусад шийдвэрт хориг тавих ийм эрхтэй. Үндсэн хуульд хориг тавих ийм заалт байхгүй. Энэний дагуу хууль хоорондын зөрчлийг арилгах ийм л асуудал процесс явагдаж байгаа гэж хэлье.

Тодруулга 1 минут.

Б.Пүрэвдорж: Энэ тэгэхээр бүхэл бүтэн нэг институцийн нөгөө институцдээ тавьдаг тодорхой хяналт бол хориг л доо. Энэ хоригийг тавих эрхийг нь шууд байхгүй болгочихож байгаа нь нэлээн асуудал үүсгэнэ. Энэний хооронд та нар зүгээр л энэ нам хоорондынхоо Их Хурал дээр байгаа хоорондынхоо зөрчлөө л нэг талдаа болго л доо. Дотоод зөрчлөө л нэг талдаа болго л доо. Та нар Үндсэн хуулийг дөрөвний гурваар батлах гэж явж байгаа юм бол гуравны нэгээр хүлээж авдаг тэр хоригийг байхгүй болгох ямар шаардлага байгаа юм бэ? Ийм энгийн юман дээр. Та нар өөрсдийнхөө л асуудлыг нэг талдаа болго.

С.Бямбацогт: Санал хэлж байна. Энд тийм нам хоорондын зөрчил гэх юм бол Ардчилсан нам, Ардын намын хооронд л яригдах байх. Энд өөр тийм зөрчил яригдах юм байхгүй байгаа байх аа.

Төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Тогтохсүрэн, Эрдэнэбатаар санал тасаллаа.

Д.Тогтохсүрэн: Бид нар түрүүн ч бас ажлын хэсэг дээр ярьсан. Ажлын хэсэг дээр яриад ажлын хэсгийн гишүүд хоёр санал байгаа юм. Нэг дэх нь 16.2, 16.3. Тэгэхээр би энэ хуулийг цаашид нь зөрчилгүй явуулах, дараагийн Үндсэн хуулиа бас үг хэлгүй явуулах үүднээсээ 16.2, 16.3 дээр орсон “Ерөнхийлөгч 3 хоногийн дотор” гэдэг. Энэийг зөвшилцлийн ажлын хэсэг дээр ярих үед нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хасмаар байна гэдэг саналыг бас байнга тавиад байгаа юм.

Тийм учраас би бол, энэ чинь Байнгын хорооноос орж байгаа тогтоол. Тийм учраас энэ дээрээ засаад Их Хуралд оруулахад боломжтой гэж би бодож байгаа. Тийм учраас 16.2-ыг хасаад, 16.3 дээр байгаа “3 хоног” гэсэн тоог хасчихвал яасан юм бэ? Ингээд маргаангүй энэ хуулиа хурдан явуулчихвал яасан юм бэ гэсэн ийм санал гаргаж байгаа юм.

С.Бямбацогт: Санал гаргах гишүүд саналын томъёоллоо бэлдээд санал хураалгаж болно. Тогтохсүрэн гишүүн дөнгөж түрүүхэн ярьж байсан асуудлаасаа хасъя, буцъя гэж байх шиг байна. Тэгээд буцах саналаа бас бэлдээд өгчихөөрэй.

Эрдэнэбат гишүүн

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Ажлын хэсэг дээр бид нар ярилцсан л даа. Тэгээд энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд Үндсэн хуулиа нийцүүлэхийн тулд өөрчлөлт оруулъя гэдэг дээр бүх намын төлөөллүүд нэг ойлголт дээр ярилцаж ойлголцсон гэж ойлгож байгаа. Эхний ажил нь энэ юм байна гээд.

Дэгийн хуулийг бас ярилцсан байгаа. Тэгээд энд яригдаагүй юм орж ирсэн нь Ерөнхийлөгчийн хоригтой холбоотой заалтыг хөндөж байгаа юм л даа. 16.2 гэдэг нь Ерөнхийлөгчийг Их Хурлаас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн эхийг уг хуулийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор хянан үзэж хэрэв уг хууль бүхэлдээ буюу түүний аль нэг зүйл, заалт, нэр томъёо, агуулга

нь Үндсэн хуульд харшилсан гэж үзвэл Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар хориг тавьж болно гээд. Энэ заалт яах аргагүй энэ хуулийн өөрчлөлтийн төсөлд ороод ирчихсэн юм.

Пүрэвдорж гишүүн яг зөв логиктой хэллээ. Би тэгээд бас Тогтохсүрэн дарга энэ заалтыг анхаарч үзээд, ярилцаагүй юман дээр гэнэт юм оруулж ирээд болохгүй, наадах чинь дахиад л хоорондын маргаан үүсгэх юм байна гэдэг дээр би санал нэгдэж байгаа юм. Тийм учраас энэ өөрчлөлтөөс энэ заалттай холбоотой зүйлийг зарчмын зөрүүтэй санал оруулаад хасах нь зөв байх аа. Үндсэн хууль чинь өөрөө эмзэг зүйл. Маш их маргаантай явж байгаа энэ үед зөвшилцөж ярилцаагүй зүйлээр гэнэт юм оруулж ирээд маргаан үүсгэвэл энэ чинь дахиад л түгжих тал руу явна шүү дээ. Тэгэхээр анхны нэг алхмаа хийж байгаа юман дээр бид нар бас аль, аль талаасаа ойлголцоод ухаантай хандаад явах нь зөв байх аа гэж би ингэж бодож байна.

Тогтохсүрэн дарга зарчмын зөрүүтэй саналын томьёолол хийж байх шиг байна. Би ч гэсэн, ингээд хоёулаа нийлж байгаад оруулчихъя. Хоёр бүлэг, зөвлөлийн дарга байна. Эрх биш энийг манай гишүүд зөв ойлгох байх гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Гишүүд саналаа хэлж дууслаа. Та хоёр 16.2, 16.3-ыг хасъя гэсэн саналын томьёолоо бэлдчих. Би энэ дээр бас нэг тайлбар хийчихье гэж бодож байгаа юм. Ерөнхийдөө Тамгын газраас, мөн зөвшилцөх ажлын хэсгийнхэн хамтарч сууж байгаад өнөөдрийн оруулж байгаа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг бэлдсэн. Бэлдэхдээ бас хэд хэдэн үндэслэл ярьсан.

Нэгдүгээрт нь, 16.2-той холбоотой асуудал, хориг тавихтай холбоотой асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Монгол Улсын Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсэн. Энд 1-д нь Монгол Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Энд Үндсэн хууль болон хууль, бусад шийдвэрт гэсэн үг байхгүй.

Ингээд ийм байхад нь Үндсэн хуульд хориг тавих юм бол өөрөө энэ чинь дахиад Үндсэн хуулиа зөрчсөн асуудал болох юм байна. Тийм болохоор хууль хоорондын зөрчил байлгахгүй байх үүднээс Үндсэн хуульд хориг тавих гэдэг асуудал 16.2 гэж Журмын тухай хуульд байж байгаа. Журмын тухай хууль үндсэндээ 2010 онд батлагдахдаа асуудалтай болчихоод байгаа шүү дээ. Тийм болохоор энийг нь хасчихъя.

Журмын тухай хуулийг өнөөдөр бид нар Үндсэн хуульдаа нийцүүлж журмын тухай хуулиа өөрчилж байгаа. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульдаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гээд нэртэй явдаг. Журмын тухай хуульд бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл гэж явдаг. Энэ маань хууль зөрчлөө гээд Ерөнхийлөгч хориг тавьсан. Бид нар хоригийг хүлээж авахдаа Үндсэн хуульдаа нийцүүлээд “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт” гэж Үндсэн хуулийн 68, 69-д заасан энэ нэр томьёогоор нь оруулж ирж энэ хуулийн зөрчлийг арилгаж байгаа.

Яг үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн журмын тухай хуульд байж байгаа хориг тавих асуудлыг Үндсэн хуульд байхгүй хориг тавих асуудлыг нь бас цэгцэлчихье гэдэг агуулгаар бид нар ажлын хэсэгт зөвшилцөж Тамгын газартай

ярьж байгаад оруулж ирсэн. Энийг та бүхэн бас зөв ойлгочихоорой. Үндсэн хуульдаа ч байж байгаа шүү дээ. Үндсэн хуулийн 68.4-т “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн адил хүчин чадалтай.” гээд Үндсэн хуульд байгаа. Энэний дагуу л бид нар оруулж ирсэн. Гэхдээ манай гишүүд дахиад л хууль хоорондын зөрчил үүсэж магадгүй шүү, үүнийгээ бас бодоорой.

Ерөнхийлөгч хориг тавихдаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр тавиагүй, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдон гарч байгаа тогтоолд тавьсан. Урьд нь ч бас хориг тавигдаж байгаагүй. Энийг та бүхэн бас нэг ойлгоод авчихаарай. Энийг бас бодоорой гэдгийг нэгдүгээрт нь хэлье.

Хоёрдугаарт нь, 16.3-ыг ярьж байгаа, “3 хоногийн хугацаа”. Энэ 3 хоногийн хугацаа гэдэг маань бас хугацаагүй байсан. Монгол Улсын Ерөнхийлөгч хуулийн эх мөн болой. Монгол Улсын Ерөнхийлөгч гарын үсэг зурж төрийн тамга дарж баталгаажуулан Үндсэн хуулиа уг эхийн хамтад нь хадгална гээд. Энийг бид нар ажлын 3 хоногийн дотор тамга дарж, гарын үсэг зурж хадгална гэдэг байдлаар өөрчилж байгаа.

Энэ маань юу болсон бэ гэхээр Үндсэн хуулийг 2000 онд өөрчлөлт оруулсан. 2000 онд оруулсан өөрчлөлтийг үндсэндээ дордуулсан долоо гэж хэлдэг өөрчлөлтийг 2000 онд оруулснаас хойш 2001 онд, бүтэн жилийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн үед Багабанди гуай гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан. Тэр болтол Үндсэн хууль маань хүчин төгөлдөр болоогүй. Хүчин төгөлдөр бус Үндсэн хуулийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар үндсэндээ Үндсэн хуулиа бас зөрчөөд л явж байсан.

Ийм бас нэг цоорхой гаргачихгүйн үүднээс тэр хуулийг нэгэнтээ Улсын Их Хурал баталсан бол, 57 гишүүн нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Монгол Улсын Их Хурлын 57 гишүүн. Ард нийтийн санал асуулгаар Улсын Их Хурал ард нийт дэмжээд баталчих юм бол тэрийг ёсчлох асуудлыг хугацаатай болгоё. Тэгэхгүй бол урьд өмнө нь гарч байсан Багабанди гуайн үед гарч байсан тэр алдааг дахиад давтчих вий гэдэг үүднээс бас хуулийн зөрчил байхгүй болгох гэж л уул нь ийм 3 хоногийн хугацаа оруулж ирсэн. Энийг хоёр бүлгийн дарга, зөвлөлийн дарга бас бодоорой. Тэгээд саналын томъёоллоор чинь санал хураая.

Үндсэн хуультай харшилсан гэж үзэх юм бол Цэц л шийдвэр гаргана шүү дээ.

Д.Эрдэнэбат, Тогтохсүрэн нарын санал. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 16.2-ыг хасах гэсэн заалтыг хасах. Мөн хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 2-ын 16.3 дахь хэсгийн Ерөнхийлөгч энэ хуулийн 16.1-д заасны дагуу биечлэн хүргэж танилцуулснаас хойш ажлын 3 хоногийн гэснийг хасах. Энэ хуулийн 16.1-д заасны дагуу биечлэн хүргэж танилцуулснаас хойш ажлын 3 өдөр гэснийг хасах. Хамтад нь хураах уу, тусад нь хураах уу?

Д.Тогтохсүрэн: Тус тусад нь хураая.

С.Бямбацогт: Тэгвэл би тусад нь хураая.

1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 16.2-ыг хасах гэсэн заалтыг хасах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Энэ хуулийн 16.1-д заасны дагуу биечлэн хүргэж танилцуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэснийг хасах. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 4 гишүүн буюу 36,4 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Санал, дүгнэлтийг Тогтохсүрэн дарга танилцуулах уу? Байнгын хорооны санал, дүгнэлтийг Цэрэнбат гишүүн танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж батлуулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцож 8 гишүүн буюу 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ Б.БАТГЭРЭЛ